Улаанбаатар хотод бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн шалтгаанаар үүссэн гавал, эрүү, нүүр орчмын гэмтлийн байдлыг судалсан дүн

Н.Очбаяр[1], Г.Батболд[1], А.Мөнхдөл[2], Б.Энх-Орчлон[1]*

[1]АШУҮИС, НАСС, Нүүр амны мэс заслын тэнхим*
[2]"Ач" Анагаах Ухааны Их Сургууль
Цахим шуудан: ochbayar@gmail.com, Утас: 99079818

Түлхүүр үг:
Гэр бүлийн хүчирхийлэл
Гавал, эрүү нүүр орчмын гэмтэл
КОВИД-19

Товч утга:
Үндэслэл: Монгол улсад гурван эмэгтэй тутмын нэг (31.2%) нь амьдралынхаа туршид бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн талаарх баримт байна.Гэр бүлийн хүрээнд тухайлбал, нөхөр/хамтран амьдрагчийн зүгээс 10 эмэгтэйн 6 нь (57.9%) амьдралынхаа туршид хүчирхийлэлд өртсөн. Эдгээрээс 4 эмэгтэй тутмын 1 нь (26.5%) хэн нэгэнд хандаж, хэлж байгаагүй байна. Дэлхий даяар тархаад буй Ковид-19 өвчний шинэ халдвараас сэргийлэхийн тулд улс орнууд тусгаарлах, хөл хорионы арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаатай зэрэгцэн гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээллэх нь өсөж, тусламж үйлчилгээний хэрэгцээ нэмэгдсэн талаар цөөнгүй судалгаанд дурьдсэн. **Зорилго:** Улаанбаатар хотод бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллээс үүссэн гавал, эрүү, нүүр орчмын гэмтлийн байдлыг судлах. **Арга, аргачлал:** Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Албанд 2019-2021 онуудад бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийн өвчний түүхийг судалсан. **Үр дүн**: Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2019-2021 оны хооронд нийт 2055 тохиолдолд ГССҮТ, Нэг цэгийн үйлчилгээ төв дээр бүртгэгдсэн байна. Эдгээрээс 2019 онд 491 тохиолдол, 2020 онд 874 тохиолдол, 2021 онд 690 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас эмэгтэйчүүд зонхилон (n=1963) 95.5% гэмтсэн бөгөөд дундаж нас 36.9±11жил байв. Харин хүчирхийлэгчдийн дийлэнх нь эрэгтэйчүүд байсан бөгөөд (n=1907) 92.8% дундаж нас 37.8±9.6 жил байв. Нийт гэмтлийн нь гавал, эрүү, нүүр орчим (n=1198) 58% тохиолдсон бөгөөд ихэвчлэн бусад хэсгийн гэмтэлтэй хавсран тохиолдож байсан бөгөөд гэмтлийн байрлалын хувьд түгээмэл тохиолдож байна. Гэмтлийн байрлалын хувьд толгой, нүүр, хамар, дух, нүд, шүд, чих болон хацрын гэмтэл түгээмэл тохиолдсон. Түүнчлэн зөөлөн эдийн болон ясны гэмтэл зонхилон тохиолдож байсан бөгөөд эдгээр гэмтэл нь цохих, өшиглөх, түлэх, хутгалах, хатуу зүйлээр цохих зэрэг шалтгаанаар үүссэн байсан. Хол хорио тогтоосон жилд үүссэн гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмтэл тайван үетэй харьцуулахад 2 дахин өссөн байгаа нь тодорхойлогдлоо. **Дүгнэлт:** Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийн дунд гавал, эрүү нүүр орчмын гэмтэл зонхилон тохиолдож байна.

Үндэслэл: Гэр бүлийн хүчирхийлэл нь хүний эрхийн хамгийн том зөрчлийн нэг төдийгүй үүний хохирогч нь дийлэнхдээ эмэгтэйчүүд болдог[1,2]. НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Байгууллагын мэдээлснээр 2019 онд 15-49 насны 243 сая охид, эмэгтэйчүүд нөхөр, хамтран амьдрагчийн зүгээс бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна. Түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэлд өртөгч нь зөвхөн эмэгтэйчүүд байдаггүй бөгөөд эрэгтэйчүүд мөн өртөж хохирогч болдог. Энэ талын мэдээлэл дутмаг, далд хэлбэртэй байдаг бөгөөд хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүдийн 40 хүрэхгүй хувь нь аливаа төрлийн тусламж хүсдэгээс 10 хүрэхгүй

хувь нь цагдаад ханддаг байна.

Монгол Улс 2016 онд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлан, 2017 оноос эхлэн мөрдөж байгаагаас гадна Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрт энэ чиглэлийн асуудлыг тусган, хэрэгжүүлж байна. Монгол Улсад гурван эмэгтэй тутмын нэг (31.2%) нь амьдралынхаа туршид бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн талаар цөөнгүй баримт байна. Гэр бүлийн хүрээнд тухайлбал, нөхөр/хамтран амьдрагчийн зүгээс 10 эмэгтэйн 6 нь (57.9%) амьдралынхаа туршид хүчирхийлэлд өртсөн. Эдгээрээс 4 эмэгтэй тутмын 1 нь (26.5%) хэн нэгэнд хандаж, хэлж байгаагүй байна.

Дэлхий даяар тархаад буй КОВИД-19 өвчний шинэ халдвараас сэргийлэхийн тулд улс орнууд тусгаарлах, хөл хорионы арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаатай зэрэгцэн гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэх нь өсөж, тусламж үйлчилгээний хэрэгцээ нэмэгджээ.[3,4]

Манай улсад 2007 оны байдлаар эрүү нүүр орчмын гэмтэл нь хүчирхийлэл үүдэлтэй гэмтэл 69.4%, ахуйн гэмтэл 11.8%, тээврийн гэмтэл 18% тус тус эзэлж байсан.[6] Гэвч ахуйн орчинд үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийллээс шалтгаалсан эрүүний нүүр орчмын гэмтлийн талаар нарийвчлан судлагдаагүй байгаа нь энэхүү судалгааны ажил хийх үндэслэл боллоо.


Зорилго: Улаанбаатар хотод бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллээс үүссэн гавал, эрүү, нүүр орчмын гэмтлийн байдлыг судлах

Зорилт:

1. Гэр бүлийн хүчирхийллээс үүссэн гавал, эрүү, нүүр орчмын гэмтлийн байдлыг судлах.
2. Гэр бүлийн хүчирхийллээс үүссэн гавал, эрүү, нүүр орчмын гэмтлийн байдлыг КОВИД-19 халдварын эсрэг тогтоосон хөл хорионы үетэй харьцуулан судлах


Арга, аргачлал: Судалгааг ретроскриптив аргаар хийж гүйцэтгэсэн. Судалгаанд Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Албанд 2019-2021 онуудад бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийн өвчний түүхийг судалсан. Статистик боловсруулалтыг SPSS 26.00 программ ашиглан Chi-Square тест ашиглан хийсэн. Судалгааны ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2021 оны 5 дугаар сарын 21 өдрийн хурлаар хэлэлцүүлж (2021/3-06) зөвшөөрөл авсан.

Үр дүн: Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2019-2021 оны хооронд нийт 2055 тохиолдолд ГССҮТ, Нэг цэгийн үйлчилгээ төв дээр бүртгэгдсэн байна (Зураг 1). Эдгээрээс 2019 онд 491 тохиолдол, 2020 онд 874 тохиолдол, 2021 онд 690 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас эмэгтэйчүүд зонхилон (n=1963) 95.5% гэмтсэн бөгөөд дундаж нас 36.9±11 жил байна. Харин хүчирхийлэгчдийн дийлэнх нь эрэгтэйчүүд байсан бөгөөд (n=1907) 92.8% дундаж нас 37.8±9.6 жил байв. (Зураг 1)



Зураг 1. Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв болон Нийгмийн Эрүүл Мэндийн Албаны нэг цэгийн үйлчилгээнд бүртгэгдсэн гэмтлийн тохиолдлын тоо

Нийт гэмтлийн 58% (n=1198) нь гавал, эрүү, нүүр орчим тохиолдсон бөгөөд ихэвчлэн бусад хэсгийн гэмтэлтэй хавсран тохилдож байсан. Гэмтлийн байрлалын хувьд толгой, нүүр, хамар, дух зэрэг түгээмэл тохиолдсон (Зураг 2).




Зураг 2. **Гавал, эрүү нүүр орчмын гэмтлийн тархалт**

Зөөлөн эдийн болон ясны гэмтэл зонхилон тохиолдож байсан бөгөөд эдгээр гэмтэл нь цохих, өшиглөх, түлэх, хутгалах, хатуу зүйлээр цохих зэрэг шалтгаанаар үүссэн байна. (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн нүүр орчмын гэмтлийг үүсгэсэн шалтгааныг судалсан дүн

Гэмтэл үүсгэсэн хэлбэр ба гэмтэл учруулсан биет	n=2359	%
Гараар цохих	1500	63.5
Өшиглөх	515	21.8
Мөргүүлэх	55	2.3
Чулуу цохих	13	0.5
Шанага цохих	3	0.1
Алх цохих	5	0.2
Хайчаар гэмтээх	16	0.6
Хутгалах	133	5.6
Төмөр цохих	16	0.6
Шил хагарах	103	4.3

Хүчирхийлэл үйлдэгч нь ихэвчлэн хамтран амьдрагч (n=849, 41%) эсвэл нөхөр (n=796, 39%), найз залуу (n=86, 4%) болон бусад (n=316, 16%) гэр бүлийн хүмүүс үйлдсэн байна. Гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Баянзүрх, болон Баянгол дүүрэгт зонхилон тохиолдсон байна (Зураг 3).



Зураг 3. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийн харьяалал

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид ихэвчлэн согтуурсан үедээ (n=423) 86% нь 2019 онд, (n=725) 83% нь 2020 онд, (n=597) 86% нь 2021 онд хүчирхийлэл үйлдсэн боловч дээрх жилүүдийн хооронд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсангүй (p=0.100). КОВИД-19 халдварын эсрэг хөл хорио тогтоосон хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн тохиолдлын тоо буурсан боловч хөл хориог сулруулсны дараа нэмэгдсэн хандлага ажиглагдаж байна (Зураг 4).



Зураг 4. 2019-2021 онд бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн тоо болон хөл хорионы хугацаа (ковид-19).

Хөл хорио тогтоосон хугацааг хүчирхийллийн тохиолдолтой харьцуулан судлахад (n=1285) 63% нь улбар шар түвшинд илүү бүртгэгдсэн байна. (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Хүчирхийлэлийн тохиолдолдын тоо болон ковид-19 түвшинтэй харьцуулсан дүн

Тохиолдлын тоо болон КОВИД-19 түвшин					
Он	Түвшин**			Нийт	P value*
	Шар	Улбар шар	Улаан		
2019	491 (100%)	0 (0%)	0 (0%)	491 (100%)	0.001
2020	152 (18%)	651 (74%)	71 (8%)	874 (100%)	
2021	0 (0%)	634 (92%)	56 (8%)	690 (100%)	
Нийт	643 (31%)	***1285 (63%)***	127 (7%)	2055 (100%)	

Тайлбар: **Chi square test, **Column percentage*

Хэлцэмж: Хүчирхийлэл нь нийгмийн ээдрээтэй үзэгдэл бөгөөд хүйсийн тэгш бус байдал зэрэг олон хүчин зүйлүүдийн нөлөөллөөр үүсдэг. Хөгжиж буй орнуудад хүчирхийллийн тархалт өндөр байгаа нь хүн амын, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал доогуур, мөн эмэгтэйчүүдийг үзэх тухайн улсын соёл, ёс заншил нь эрчүүдийн янз бүрийн зан үйлийг хүлээн зөвшөөрөхийг далд хэлбэрээр дэмждэг зэрэгтэй холбоотой байдаг.[5] Хэрэв хохирогч эмэгтэй бол хүйсийн эмзэг байдлаас шалтгаалан хохирогчид бие махбодын хүчирхийлэлд өртсөн байх магадлалтай тул гэмтлийн байршлаас үл хамааран хэргийг шалгах ёстойг судлаачид онцолсон байна.[6,7]

Бразил улсад хийгдсэн судалгааны үр дүнгээс харахад хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн дундаж нас 27 байсан бол бидний судалгаад хамрагдагсдын дундаж нас 37 байсан ба аль аль нөхрөөсөө санхүүгийн хамааралтай гэрийн эзэгтэй нар голчлон хохирогч болсон. Ихэнх тохиолдолд хохирогчийг таньдаг эрэгтэй гэмт хэрэгтэн байдаг. Энэ утгаараа судалгаа хийх ёстой эрсдэлт бүлгийн хүн амыг судалж, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, өвчлөлтэй тэмцэх шаардлагатайг өмнө хийгдсэн судалгаа онцолсон нь бидний судалгааны үр дүнтэй дүйж байна.

Гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй эрүү нүүрний гэмтлийн тархалт өндөр байдаг бөгөөд хүний нүүр царай нь гоо зүйг бүрдүүлж буй чухал хэсэг тул санаатайгаар энэ хэсгийг гэмтээх үйлдлийг хүчирхийлэл үйлдэгч гаргадаг байна. Luzia M нарын судалгаагаар амны хөндийн болон эрүү нүүрний гэмтлийн тархалт өндөр байгааг тогтоосон бөгөөд түрэмгийлэгчид нь хохирогчдыг айлган сүрдүүлэх, доромжлох зорилготой байсан. Бидний судалгаагаар дээрх судалгааны ажлын үр дүнтэй ойролцоо тодорхойлогдлоо.

Хохирогчийн оршин суугаа газар нь тархвар судлалын үүднээс маш чухал хувьсагч юм. Судалгааны дүнгээс харахад хотын захад амьдардаг эмэгтэйчүүд эрүү нүүрний гэмтэлд илүү өртсөн. Хүчирхийллийн механизм нь эрүү нүүрний гэмтлийн хохирогчдыг судлахад нэг чухал хувьсагч юм. Хүчирхийллийн хамгийн түгээмэл механизм нь өшиглөх, түлхэх, цохих гэх мэт биеийн хүчээр үйлдэгдсэн байна.

Эрэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийллийг голлон үйлдэгч байсан нь бусад судалгаануудын мэдээлэлтэй дүйж байна.[8,11,12]

КОВИД-19 халдварын үед засгийн газраас авч хэрэгжүүлсэн хөл хорионы улбар шар түвшинд орон байр, гэрийн хүчирхийлэл бусад үетэй харьцуулахад нэмэгдсэн. Хөл хорионы улаан үед гэр бүлийн хүчирхийллийн тохиолдолд багассан боловч хөл хориог сулласны дараа огцом нэмэгдсэн дүр зураг ажиглагдсан. Энэ нь магадгүй улаан түвшний хөл хорионы үед хохирогч гэрээс гарах боломжгүй байсантай холбоотой байж болох бөгөөд хөл хорио суларсны дараа тусламж авахаар хандсан байх магадлалтай юм.

Дүгнэлт:

1. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийн дунд гавал, эрүү нүүр орчмын гэмтэл зонхилон тохиолдож байна.
2. КОВИД-19 халдварын эсрэгт хөл хорио тогтоосон хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол нэмэгдсэн байна.

Ном зүй:

1. *Halpern LR. Orofacial Injuries as Markers for Intimate Partner Violence. Oral Maxillofac Surg Clin North Am. 2010;22(2):239-246. doi:10.1016/j.coms.2010.01.009*
2. *Melville JD, McDowell JD. Domestic Violence. In: Forensic Odontology. Elsevier; 2018:121-144. doi:10.1016/B978-0-12-805198-6.00007-4*
3. *Olding J, Zisman S, Olding C, Fan K. Penetrating trauma during a global pandemic: Changing patterns in interpersonal violence, self-harm and domestic violence in the Covid-19 outbreak. The Surgeon. 2021;19(1):e9-e13. doi:10.1016/j.surge.2020.07.004*
4. *Coulthard P, Hutchison I, Bell JA, Coulthard ID, Kennedy H. COVID-19, domestic violence and abuse, and urgent dental and oral and maxillofacial surgery care. Br Dent J. 2020;228(12):923-926. doi:10.1038/s41415-020-1709-1*
5. *Ali AA, Yassin K, Omer R. Domestic violence against women in Eastern Sudan. BMC Public Health. 2014;14(1):1136. doi:10.1186/1471-2458-14-1136*
6. *Ferreira MC, Batista AM, de Oliveira Ferreira F, Ramos-Jorge ML, Marques LS. Pattern of oral-maxillofacial trauma stemming from interpersonal physical violence and determinant factors. Dental Traumatology. 2014;30(1):15-21. doi:10.1111/edt.12047*
7. *Sheridan DJ, Nash KR. Acute Injury Patterns of Intimate Partner Violence Victims. Trauma Violence Abuse. 2007;8(3):281-289. doi:10.1177/1524838007303504*
8. *da Nóbrega LM, Bernardino Í de M, Barbosa KGN, e Silva JAL, Massoni AC de LT, d'Avila S. Pattern of oral-maxillofacial trauma from violence against women and its associated factors. Dental Traumatology. 2017;33(3):181-188. doi:10.1111/edt.12327*
9. *Caldas IM, Grams AC, Afonso A, Magalhães T. Oral injuries in victims involving intimate partner violence. Forensic Sci Int. 2012;221(1-3):102-105. doi:10.1016/j.forsciint.2012.04.010*
10. *da Nóbrega LM, Bernardino Í de M, Barbosa KGN, e Silva JAL, Massoni AC de LT, d'Avila S. Pattern of oral-maxillofacial trauma from violence against women and its associated factors. Dental Traumatology. 2017;33(3):181-188. doi:10.1111/edt.12327*
11. *Frank S, Coelho EBS, Boing AF. Perfil dos estudos sobre violência contra a mulher por parceiro íntimo: 2003 a 2007. Revista Panamericana de Salud Pública. 2010;27(5):376-381. doi:10.1590/S1020-49892010000500008*
12. *Driessen MLS, van Ditshuizen JC, Waalwijk JF, et al. Impact of the SARS-CoV-2 pandemic on trauma care: a nationwide observational study. European Journal of Trauma and Emergency Surgery. 2022;48(4):2999-3009. doi:10.1007/s00068-022-01891-5*

Pattern of the domestic violence-related craniofacial trauma during the lockdown in Ulaanbaatar, Mongolia

Ochbayar N[1], Batbold G[1], Munkhdul A[2], Enkh-Orchlon B[1]*

[1]Department of Oral and maxillofacial surgery, School of dentistry, MNUMS
[2]"Ach" university
E-mail: nochbayar@gmail.com, Tel: +976-99079818

Background: The pandemic of SARS2 has been changing the way we live dramatically. The number of cases has increased considerably in many countries around the globe. Some countries experienced a shortage of medical doctors, and facilities to take care of the patients. Therefore, lockdowns have been implemented in numerous countries to control the infection rate. Mongolia is one of those countries, and during the lockdown, almost everyone must stay home except the first responders. Under the COVID-19 lockdown, the number of domestic violence-related trauma has been raised.
Aim: The aim of the study was to evaluate and compare the incidence of domestic violence-related craniofacial trauma before and during the lockdowns.
Materials and Methods: We retrospectively reviewed 2055 cases of domestic violence-related trauma between 2019-2021 at the National Traumatology and Orthopedics Research Center of Mongolia, and there was 491 cases in 2019, 874 cases in 2020, and 690 cases in 2021 respectively.
Results: Among them 1198 (58%) were located in the craniofacial region concomitant with other traumas. The majority of cases were located head, face, nose, followed by the forehead, eyes, teeth, ear, and cheek. Types of injuries were soft tissue, bony fractures followed by burns, stab, and concussion. The victims were mainly female (1963, 95.5%) with a mean age of 36.9±11 years old whereas aggressors were male (1907, 92.8%) with a mean age of 37.8±9.6 years old. During the lockdowns, the number of domestic-related trauma were increased compared with the pre-pandemic year.
Conclusions: The women are the majority of victims and mainly suffered from craniofacial traumas including soft tissue injuries, bony fractures.

Keywords: Domestic violence, Craniofacial trauma, COVID19, Lockdown